

Өв залгамжлал болон бэлэглэлийн татварын үүсэл, олон улсын туршлага

The history and international practice of inheritance and gift tax

М.Мишигдорж¹, Д. Лхагвасүрэн², Л. Хишигбаяр³

Хураангуй

Хөрөнгийн шилжилттэй холбоотой татварын харилцаа манай улсын хууль, эрх зүйн хүрээнд тодорхой зохицуулагдаагүй байгаа ч ирээдүйд зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай асуудлын нэг юм. Энэхүү судалгаанд өв залгамжлал болон бэлэглэлийн албан татварын үүсэл хөгжил, хэрэгцээ шаардлага олон улсын туршлагыг авч үзсэн. Судалгаа нь Монгол улсын хүрээнд өв залгамжлал, бэлэглэлийн татварын зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор хийгдсэн болно.

Түлхүүр үг: татвар, хөрөнгийн шилжилт, өв залгамжлал болон бэлэглэл

Abstract

Tax relations related to the transfer of assets are not clearly regulated in the legal respect of our country, but this is one of the issues that need to be consider in the future. This study examines the origins, development and needs of inheritance and gift taxes and international experience. The purpose of the study is to support the improvement of inheritance and gift tax regulations in Mongolia.

Key word: tax, asset transfer, inheritance and gift transfer

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхим, Доктор (Ph.D)
E-mail: mishigdorj@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль Нягтлан бодох бүртгэлийн тэнхим
E-mail: dlkhagva@num.edu.mn

³ МУИС-ийн Бизнесийн Сургууль Нягтлан бодох бүртгэлийн тэнхим,
E-mail: khishigbayar@num.edu.mn

Оршил

Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын төрлийг Татварын ерөнхий хуулиар татварын нэг төрөл хэмээн тодорхойлсон ч тухайн төрлийн татварын хувь хэмжээг тогтоосон хуулийг Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлаагүй төдийгүй өв залгамжлал, бэлэглэлийн татварын асуудлыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар мөн зохицуулаагүй байдаг. Өөрөөр хэлбэл, өв залгамжлалаар бий болсон хөрөнгө, орлогод өв залгамжлалын албан татвар хамаарах авч тухайн төрлийн татварын хувь хэмжээг тогтоосон хууль тогтоомж батлагдаагүй байна. Иймд энэхүү судалгааны ажилд өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын үүсэл хөгжил, манай улсад хууль эрхзүйн зохицуулалт ямар баримт бичгүүд байгааг тодруулахыг зорилоо.

Судлагдсан байдал

Манай улсад өв залгамжлал, бэлэглэлийн асуудлыг эрхзүйн талаас нь судалсан судалгааны ажлууд багагүй байдаг боловч татварын талаас нь судалсан судалгаа хомс байна.

Б.Улаанбаатар (2018) “Гэрээслэлээрх өв залгамжлалын эрх зүйн шинэчлэлтийн тулгуур асуудал” судалгаандаа өв залгамжлалын эрх зүй нь эрх залгамжлалын асуудалтай салшгүй холбоотой гэж үзсэн. Манай улсын эрх зүй, иргэний эрх зүйн онолд эрх залгамжлалын асуудал бараг судлагдаагүй орхигдсон байна гэж дүгнэсэн. Н.Нарангэрэл (2013) “Монгол, БНХАУ-ын өв залгамжлалын хуулийн харьцуулсан судалгаа” бүтээлдээ Хятад улсын өв залгамжлалын хуульд “Хууль ёсны өвлөгчид нь тэгш эрхтэйгээр

өв хөрөнгөө авах эрхтэй” гэж заасан ба өвлөгчид нас барагчийг асран тэтгэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд оногдох хувийг өгөхгүй байхаар заасан. Мөн өв залгамжлагч гэрээслэлийг хуурамчаар зохиосон, өөрчилсөн, устгасан бол өв залгамжлах эрхээ алдахаар заасан байдаг. Эдгээр хуулийн санааг манай улсын хувьд энэ төрлийн хуульдаа тусгах боломжтой гэж үзсэн. Н.Ариунзаяа (2003) “Олон улсын хувийн эрх зүй дэх өв залгамжлалын асуудал” судалгаандаа өв залгамжлалын харилцаанд нарийвчилсан зохицуулалт хийх шаардлагатай байгаа. Ингэхдээ нотариатын байгууллагын оролцоог тодотгох байдлаар дотоодын хууль тогтоомжоо нарийн зохицуулалттай болгох замаар хэрэгжүүлэлтийг эхлүүлэх нь зүйтэй гэж үзсэн. А.Батболд (1998) “Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт” гэсэн судалгааны ажилдаа өв залгамжлалын эрх зүй нь иргэний эрх зүйн нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нас барагчийн өв хөрөнгө эрх үүрэг бусад этгээдэд шилжихтэй холбогдсон харилцааг зохицуулдаг хэм хэмжээний цогц юм. Өв залгамжлал нь монголын болон гадаад орнуудын эрх зүйн тогтолцоонд өмчийн эрх үүсэх чухал үүсмэл аргуудын нэг болохын зэрэгцээ энэхүү харилцааг хамгаалах хялбаршуулан зохицуулах зорилгыг агуулна гэжээ.

Брючко Татьяна Александровна (2011) “Иргэний хуульд заасан өв залгамжлалын онол практикийн асуудал” бүтээлдээ өв залгамжлалтай холбоотой түүхэн эх сурвалжаас эхлэн өнөөгийн өндөр хөгжилтэй орнуудад авч үзэж буй ойлголтуудыг харьцуулах замаар Оросын хуулийн хүрээнд зохицуулагдаж буй харилцааг сайжруулахыг зорьсон бөгөөд энэхүү ажилдаа өв залгамжлалын эрх

зүй нь иргэний эрх зүйн маш консерватив салбар юм гэж цохон тэмдэглэсэн байна. Фесслер, Пирмин болон Мартин Шурц нар (2018) “Европын улсуудын хувийн баялаг: Орлого, өв залгамжлалын төрд үзүүлэх нөлөөлөл” бүтээлдээ хүлээн авч буй өв залгамжлал болон баялгийн түвшин хоорондын эерэг хамаарлыг тодорхойлсон бол Семенов Моше болон Ной Левин Эпштейн нар (2013) “Баялагт хүрэх зам: 16 орны өрхийн баялаг” бүтээлдээ өрхийн баялагтай энэхүү асуудлыг холбон авч үзсэн байна.

ЭЗХАХБ (Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага) нь өөрийн 37 гишүүн орнуудын өв залгамжлал, үл хөдлөх хөрөнгийн болон бэлэглэлийн татварын харьцуулсан үнэлгээг өгдөг бөгөөд эдгээр татварууд нь орлого нэмэгдүүлэх, тэгш бус байдлыг арилгах, ирээдүйд татварын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэхэд ямар үүрэг гүйцэтгэж болохыг судалдаг. ЭЗХАХБ-ын 11/05/2021 шинэ тайланд дурдсанаар өв залгамжлалын татвар нь баялгийн тэгш бус байдал өндөр байгаа өнөөгийн нөхцөлд, тэр тусмаа COVID-19 цар тахалтай холбоотой төрийн санхүүд шинэ дарамт шахалт үзүүлж байгаа энэ үед тэгш бус байдлыг шийдвэрлэх чухал хэрэгсэл болж чадна гэж дүгнэсэн байна.

Өв залгамжлал, бэлэглэлийн татварын үүсэл, хөгжил

Өв залгамжлал болон бэлэглэлийн татвартай холбоотой мэдэгдлүүд нь эртний Египетийн папирус дээр болон Эртний Ромын булшны бичвэрүүд дээр тэмдэглэгдэн үлдсэн байдаг бөгөөд энэхүү хөрөнгийн харилцаа тэдгээр соёл иргэншлийн хөгжлийн хэр өндөр төвшинд байсныг харуулж байна гэж түүхчид үздэг

байна.

Энэ төрлийн татвар нь *vicesima hereditatium* гэдэг нэршилтэйгээр манай эриний өмнөх үед Эртний Ромд ашиглагддаг байжээ. Өнөөг хүртэл яг хэдэн оноос эхлэн тус татварын харилцаа байсан талаар тодорхой судалгаа байхгүй байгаа бөгөөд зарим нэг эх сурвалжуудад Ромын эзэнт гүрний 757 онд (м.э 4 он) анхлан үүссэн гэдэг нөгөө хэсэг нь Актавиан Августины 755 онд (м.э 6 он) *Lex Julia Vicesimaria* хуулиар тус татварыг хуульчилж өгсөн гэж тодорхойлдог байна. Ромын Эмпирактор ард иргэдээ эд баялгаа харилцан бие биедээ /гэр бүлийн бус хүмүүст/ бэлгэлэн баярхах болсныг анзаарч тус харилцаатай холбоотойгоор 5% татвар авах болсон бөгөөд цугларсан татварыг батлан хамгаалахын санд төвлөрүүлж Ромын лигионы ахмад дайчдад олгодог тэтгэмжийг санхүүжүүлэхэд зарцуулдаг байсан байна (Ёсихиро, 2014). Мөн судлаач Д.Львовын судалгаагаар Эртний Ромын Антониев, Октавиан болон Лепидийн триумфир /буюу гуравласан захиргааны хэлбэр/-ийн Помпей-ийн Секстагийн эсрэг хийсэн дайны үед дайн тулааны санхүүжилт бүрдүүлэх зорилгоор гаргасан татварын хэлбэр гэж үзсэн байдаг. Энэхүү татварын тухай Цезарийн найз, хуульч- *Aulus Ofilius*-хамгийн анхлан тайлбар бичиг үйлдсэн байдаг байна.

Энэхүү *vicesima* татварыг нийт Ромын иргэдээс хөрөнгийн 1/20 хувиар, буюу 5% татвар авдаг байсан бөгөөд бүхий л татварыг хүчингүй болгож хөнгөлсөн цаг үеүдэд ч нэг ч удаа хөнгөлөлтөд хамрагдаж байгаагүй татвар аж.

Мөн энэхүү татварыг нэвтрүүлэх болсон нэг гол хүчин зүйл нь Ромын иргэдийн гэр бүлийн харилцаанаас татгалзан чөлөөт

амьдралаар амьдрах болсон хандлагыг багасгах зорилгыг мөн агуулж байжээ. Д.Львовын хийсэн судалгаагаар энэхүү татварын санааг тэд Эртний Египетийн м.э.ө 300-31 оны Лагидовийн хаанчлалын үеийн папирус дээрх өв залгамжлалын татварын тухай бичвэрээс улбаатайгаар авсан байна (Оюунаа, 2017).

Каракаллагийн үе буюу 198-217 онд татварын нэршлийг *vicesima* (1/20)-г *decimal* (1/10) болгон сольж хувийг 10% болгоод зогсохгүй бүхий л бэлэг, сэлтээс татвар авах болсноор орж ирэх татварын хэмжээ нэмэгдсэнээр барахгүй татварын орлогын ихэнх хэсгийг бүрдүүлэх болсон байна. Энэхүү татварыг хөрөнгийг зарж борлуулах үед ч ногдуулдаг байсан бөгөөд ихэнх тохиолдолд худалдагчаас нь зарим онцгой нөхцөлд худалдан авагчаас давхар авдаг байсан байна. Мөн худалдагч тал нь худалдан авагчаасаа тухайн харилцаатай холбоотой үүссэн татварыг авах эрхтэй байжээ.

Энэ өв залгамжлал болон бэлэглэлийн татвар нь нэгдүгээр Юстинианы үед буюу 533 онд цуцлагдсан гэж үздэг боловч зарим түүхчид газрын татварыг анх авч эхэлсэн Диоклетианын үед буюу 285-305 онд тус татвараар сольсон ч гэж үздэг байна (Новицкого, Юрист, 1999).

Vicesima (decima) hereditatium хэмээх энэ татвар нь Европын улс орнуудын хөрөнгийн шилжилт хөдөлгөөнд ногдуулах татварын харилцааг зохицуулах хууль эрх зүйн баримтын үндэс нь болжээ. Европт энэ төрлийн татварыг анхлан Голландад арван долоодугаар зуунд ногдуулж эхэлсэн бөгөөд тухайн үед Октавиан Августины хуулиас иш татан оруулсан гэдгээ бичиж тэмдэглэсэн байдаг байна. Тус татвар нь өвлөн авч буй этгээдийн

төрлийн холбооноос хамааран 5-аас 30% байсан бөгөөд татварын орлого нь батлан хамгаалахын зардалд зарцуулагддаг байжээ.

Үүний дараагаар Англичууд ч өөрийн хууль эрх зүйн зохицуулалтад тусгасан бөгөөд нийт өв залгамжлалаар очиж байгаа хөрөнгийн 1/3 % татвар ногдуулдаг байжээ. Ингэхдээ 1953 оныг хүртэл хөрөнгө нь садан төрлийн хүнд өвлөгдөж байгаа тохиолдолд татвараас чөлөөлөгдөж байсан бол үүнээс хойш өв залгамжлагчийн насанд үндэслэн татварын хэмжээг тодорхойлох болсон байна. Англи улсаас улбаалан энэхүү татвар нь цаашид бүхий л Европын улсуудаар тархсан бөгөөд арван есдүгээр зуун хүртэл дунджаар 5%-иар татвар ногдуулан авдаг байжээ. Арван есдүгээр зууны эдийн засгийн өсөлт болон татварын олон жилийн түүхэн хөгжилтэй холбоотойгоор энэхүү татвар нь өөрийн хөгжлийн дээд цэгтээ хүрсэн гэж хэлэхэд болох юм. Өөрөөр хэлбэл энэ төрлийн татвар нь улсын төсвийг бүрдүүлэх нэг эх үүсвэр болоод зогсохгүй хөрөнгийг хөндлөнгийн хүн эзэмшихээс хамгаалсан томоохон бодлогын илрэл болох болжээ (Демин, 2010)

Олон улсын туршлага

Одоогийн байдлаар 34 улс энэ татварыг ашигладаг. ЭЗХАХБ-ын 37 орноос 24 орон нь өв залгамжлалын татвар ногдуулдаг. Эдгээр орнууд нь нийгмийн тэгш бус байдлыг арилгах гол хүчин зүйл нь өв залгамжлалын татвар гэж үздэг. Харин зарим орны хувьд өв залгамжлалын татвар нь ирээдүйн баялгийг бий болгоход саад учруулж байдаг гэж үздэг тул хууль эрх зүйн зохицуулалтандаа тусгадаггүй байна.

Хүснэгт 1. Улс орнуудын өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын зохицуулалт, хувь хэмжээ

№	Улс	Татварын төрөл	Хувь хэмжээ
1	Канад	Канад улсын өв залгамжлалын хуулиар тухайн нас барсан этгээд амьд ахуйдаа өв залгамжлагчид өв хөрөнгийг борлуулсан мэт үзэж ашгийн татвар ногдуулан авдаг.	0
2	Мексик	Өв залгамжлалын татвар гэж байхгүй. Төрсөн үр хүүхдэд нь хөрөнгө өвлөгдөж буй тохиолдолд татвар ногдуулдаггүй, бусад этгээдүүдийн хувьд өвлөгдөж байгаа хөрөнгөнд орлогын албан татвар ногдуулдаг.	0
3	Макао	Өв залгамжлагчид ээлтэй хууль бүхий орны тоонд орох бөгөөд өв залгамжлалын татвар бус хөрөнгө шилжүүлсний төлбөр хэлбэрээр авагддаг байна. Мөн бэлэглэл болон хөрөнгийн үнэ цэнийн өсөлтийн татвар гэж байдаггүй. Гадаад улсаас олсон эх үүсвэр бүхий орлогын хувьд татвараас чөлөөлөгдөх орлогод тооцдог.	0,4-5,0%
4	Белги	Өв залгамжлал нь нөхөр болон хүүхдүүдэд өвлөгдсөн тохиолдолд 30%, бусад хамаатнуудаас өвлөгдөн ирж байгаа тохиолдолд 65%, хэрвээ цусан төрлийн холбоогүй хүнд өвлөгдвөл 80% хувиар татвар ногдуулдаг байна	30%, 65%
5	Гонконг	2016 оноос хойш өв залгамжлалын татвар ногдуулахгүй байгаа бөгөөд энэ орны хуулийн хүрээнд хөрөнгийн болон бэлэглэлийн албан татвар үйлчилдэггүй	0
6	Сингапур	2008 оноос хойш өв залгамжлалын татвар ногдуулахгүй байхаар болсон нь хөрөнгө шилжүүлэх үйл явцыг хялбарчилж өгсөн байна. 2019 оноос тус татварыг дахин ногдуулах асуудлыг авч үзэж байна.	0
7	Шинэ Зеланд	Энэ улсад өв залгамжлалын татвар байдаггүй хэдий ч өв залгамжлан авч буй хөрөнгөтэйгөө холбоотойгоор татварын албанд татварын мэдүүлэг бөглөж өгдөг байна.	

8	Австрали	1979 оноос хойш ногдуулаагүй байна.	0
9	Япон	Тус улсын татварын орлогын багагүй хувийг өв залгамжлалын татвар эзэлдэг. 2014 оныг хүртэл тус татвар нь зөвхөн чинээлэг давхаргын хүмүүст буюу нийт хүн амын 4%-д л ногдуулдаг байсан бол татварын хуулийн шинэчлэлттэй холбоотойгоор 2015 оноос хойш дундаж давхаргын хүмүүст мөн ногдуулах болсон. Өмнө нь татварыг (50 сая иен + 10 сая иен * хууль ёсны өв залгамжлагчдын тоо)-гоор үржүүлж тооцдог байсан бол 2015.01.01-ээс эхлэн (30 сая иен+6 сая иен* хууль ёсны өв залгамжлагчдын тоо) болгон өөрчилсөн.	55%
10	АНУ	Хөрөнгө нь эхнэр, нөхрөөс өв залгамжлагдан ирсэн бол татварын 0%, бусад хүнээс бол 40% хувиар татвар ногдуулдаг. Муж тус бүр өөрийн дотоод журмаар татварын тодорхой хөнгөлөлтийг зохицуулан олгодог.	40%
Европын холбооны орнууд			
11	Болгарь	Өв залгамжлалын татварын хэмжээ нь цусан төрлийн холбоо хамаарлаар тодорхойлогддог. Ойрын төрлийн хүмүүсийн хувьд татварын 0%, хамаатнуудын хувьд 0,3-0,8%, бусад өв залгамжлах эрх бүхий этгээдүүдийн хувьд 6,6%-иас хэтрэхгүй татвар төлдөг.	0-6,6%
	Испани, Грек, Герман	1 сая еврогоос дээш үнийн дүнтэй хөрөнгөд татвар ногдуулна Испани 7,6-34% Грек 36% Герман 7-50%	34-50%
	Португали, Чех, Люксембург	Ямар нэг татвар авахгүй	0
	Турк	Нийт хөрөнгөнд	1-10%

	Черногор	Нийт хөрөнгийн үнэлгээнээс заагдсан хувиар татвар ногдуулдаг	3%
	Хорват	Нийт хөрөнгөнд	5%
	Финлянд,		
	Их британи	Нийт хөрөнгөнд	36%
	Белги	Нөхөр болон хүүхдүүдэд хөрөнгө өвлөгдсөн тохиолдолд 30%, бусад хамаатнуудад бол 65%, цусан төрлийн холбоогүй хүнд бол 80% хувиар татвар ногдуулдаг байна.	30%, 65%
	Эстони	Өв залгамжлалын татвар гэж байхгүй. Гэхдээ өвлөгдсөн хөрөнгийг орлоготой адилтган орлогын албан татвар ногдуулдаг	20%

Эх сурвалж: International wealth хөрөнгийн диверсификаци болон олон улсын хамгааллын нэгдсэн портал

Эх сурвалж: А. Ёсихиро Японы өнөөгийн тусгал Nippon.com 2014-12-22 хэвлэгдсэн нийтлэлээс иш татав

Олон улсын түвшинд хамгийн шударга татвар гэж үнэлэгддэг энэ төрлийн татвар нь өв залгамжиллаж буй хүн нь тус хөрөнгийг хурааж хуримтлуулж, олж эзэмшихэд хэр хэмжээний хичээл зүтгэл гаргасан гэдгээсээ хамаараад хувь хэмжээ болон татварын ачаалал нь зохицуулагддаг нийтлэг жишиг үйлчилж байна.

МУ-ын өв залгамжлалтын татварын өнөөгийн байдал

Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-т Монгол улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно гэж заасан байна.

Нотариатын тухай хуулийн 40-р зүйлд Гэрээслэл гэрчлэх, 42-р зүйлд Өвлөгдөх

эд хөрөнгийг хамгаалах, 43-р зүйлд Өвлөх эрхийн гэрчилгээ олгох, 48-р зүйлд Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгээ өмчлөх эрхийг гэрчлэх эрхтэй хэмээн нотариатчийн үйлдлийг зааж өгсөн байдаг.

Нотариатч нь өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах, өвлөх эрхийн гэрчилгээ олгох гэсэн хоёр үүрэгтэйгээр өв залгамжлалын харилцаанд оролцдог. Нотариатын байгууллагын хувьд өв залгамжлалтай холбоотойгоор өвлөх эрхийн гэрчилгээ олгохдоо үйлчилгээний хөлс болох 1% -ийн дүнг авдаг.

Иргэний хуулийн 54-59-р бүлэгт өв залгамжлалтай холбоотой асуудлыг тайлбарладаг.

Монгол улсад дараах дарааллаар өв залгамжлуулдаг байна (Янжул, 2002).

Үүнд:

- Гэрлэлтээ бүртгүүлсэн нөхөр, эхнэр, төрсөн ба үрчилсэн хүүхэд, нас барсны дараа төрсөн хүүхэд, төрсөн болон үрчилсэн эцэг, эх
- Өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүүс, ач, зээ
- Ачинцар, зээнцэр

Дээрх өв залгамжлагч нь нас барсан этгээдээс өөр хаягтай бол хөрөнгийг хүлээн авах хүсэлтээ өвлүүлэгчийг нас барснаас хойш 1 жилийн дотор өвлүүлэгчийн оршин сууж байсан харьяаны нотариатчид бүртгүүлнэ. Гэрчилгээг өвлүүлэгч нас барсан өдрөөс хойш 1 жил өнгөрсний дараа олгох ба хүсэлт гаргаагүй тохиолдолд хөрөнгөнөөс татгалзсан гэж үздэг. Харин нэг хаягт оршин суудаг бол хүсэлт гаргахгүй байж болдог байна.

Өв хөрөнгийг хүлээн авахаас татгалзаж байгаа бол өвлүүлэгчийг нас барсан өдрөөс хойш гурван сарын дотор нотариатчид гарган бүртгүүлнэ.

Хэд хэдэн өвлөгчид байгаа тохиолдолд өв хөрөнгийг хуваарилах тухай хэлцлийг нотариатчаар гэрчлүүлэх боломжтой ба эвийн журмаар тохиролцохгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлдэг байна. Монгол улсад үнэт цаасыг бэлэглэх, өвлүүлэх үйл ажиллагааг СЗХ-ны 2007 оны 162-р тогтоолын дагуу “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам”-иар зохицуулж байна (Юдевич, 2013).

Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхээ бусдад бэлэглэх үед гүйлгээ хийх өдрөөс өмнөх тухайн үнэт цаасны арилжааны сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, хэрэв сүүлийн

Хүснэгт 2. Үнэт цаас шилжүүлэх үеийн шимтгэл

Д/д	Гүйлгээний төрөл	Үйлчилгээний хөлс
1	Журмын 2.2-т зааснаар өөрийн эхнэр, эсхүл нөхөр, өөрийн болон эхнэр, эсхүл нөхрийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, авга, нагац, ах, эгч, дүү, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхэд, ач зээ, тэдгээрийн хүүхэд зэрэг төрөл, садангийн хүнээс гадна хүргэн, бэрд бэлэглэж байгаа бол	Бэлэглэгч талаас -5 %
2	2.2-т зааснаас бусад иргэн хуулийн этгээдэд бэлэглэх тохиолдолд	Бэлэглэгч талаас – 10% Бэлэг хүлээн авагч талаас -10%
3	2.2-т зааснаас бусад 50-иас дээш тооны иргэн, хуулийн этгээдэд бэлэглэж	Бэлэглэгч талаас – 5% Бэлэг хүлээн авагч талаас –10%

Эх үүсвэр: СЗХ-ны 2007.11.12-ны 162 тоот тогтоолын хавсралт журмаас

52 долоо хоногт арилжаа хийгдээгүй бол тухайн үнэт цаасны нийт арилжааны дундаж ханшийг тухайн гүйлгээгээр шилжүүлж буй үнэт цаасны тоонд үржүүлж шимтгэлийг тооцдог. Нас барагчийн “ҮЦТХТ”, “ҮЦАТТ” болон клирингийн банкин дахь хөрөнгийг хууль ёсны өвлөгч нь өвлөн авахдаа нотариатын өвлөх эрхийн гэрчилгээний дагуу шилжүүлэн авдаг байна.

Татварын ерөнхий хуулийн хоёр дугаар бүлгийн 7.2.22-т заасан Монгол улсын хэмжээнд үйлчилж буй татварын төрөлд өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар гэсэн нэр томъёо орсон хэдий ч өнөөг хүртэл тус татвартай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтын бичиг баримт

боловсруулагдаагүй байна.

Мөн өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар ч давхар зохицуулагддаггүй. Тодруулбал, хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль-аар зохицуулна гэж заасан байдаг хэдий ч өв залгамжлал, бэлэглэлтэй холбоотой харилцааны хүрээнд тодорхой зүйл заалт тусгагдаагүй байна.

Судлаачдын зүгээс энэ татварын хүрээнд зохицуулагдахгүй үлдэж буй харилцаа Монгол улсын хэмжээнд хэр их байдаг талаар судлан үзлээ.

Хүснэгт 3: Бэлэглэлийн болон өвлөх эрхийн гэрээний тоо

Гэрээний нэр	2019 он	2020 он	2021 он
Бэлэглэлийн гэрээ	9,430	16,669	23,743
Өвлөх эрхийн гэрээ	3,479	9,749	23,598

Эх үүсвэр: Монголын нотариатчидын танхим-Мэдээллийн ажилтнаас

Дээрх судалгааны дүнгээс харахад худалдах худалдан авах гэрээний татвараас зайлсхийх асуудалтай холбоотойгоор бэлэглэлийн гэрээний тоо сүүлийн жилүүдэд өссөн байх боломжтойг харуулж байна. Иймд энэ төрлийн татварын хууль эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй тусгаж өгөх шаардлагатай байна.

Үүнээс гадна Монгол улсын хувьд 1990 оны зах зээлийн шилжилтийн үед үүссэн өрхийн бизнесүүд өнөөдөр үндэсний хэмжээний монополь компани болтлоо хөгжсөн төдийгүй үйл ажиллагаа нь ч олон салбарыг хамарч байна. Мэдээж сайн татварын гол зарчим болох шударга байх зарчмын хүрээнд нийгмийн баялгаас

илүү их үр шим хүртэж байгаа хүн илүү өндөр татварыг төлж нийгмийн хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрийг оруулах нь зүйн хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд өв залгамжлагчид нь компани удирдаж эхэлсэн нь энэ төрлийн татварын зохицуулалт зайлшгүй хэрэгтэй болохыг харуулж байна.

Дүгнэлт

Монгол Улсын иргэний өв залгамжлалаар бий болсон хөрөнгө, орлогод өв залгамжлалын албан татвар хамаарах боловч тухайн төрлийн татварын хувь хэмжээг тогтоосон хууль тогтоомж батлагдаагүй. Мөн өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зохицуулалтад ч хамаарахгүй байна.

Өв залгамжлалын болон бэлэглэлийн татварын үүсэл хөгжлийн түүхээс харахад тухайн төрлийн татвар нь баялгийн шударга хуваарилалт болоод зогсохгүй далд эдийн засгийг ил болгох боломжийг олгодог гэж олон судлаачид дүгнэсэн байдаг. Тэрчлэн энэ төрлийн татвартай улсад авлигын хэрэг буурдаг гэсэн эерэг үзүүлэлт ч байдаг байна. Иймд манай улсын нөхцөл байдал болон олон улсын туршлагад үндэслэн энэ төрлийн татварын зохицуулалтыг яаралтай хийснээр төсвийн орлого бүрдүүлэх нэг томоохон эх үүсвэр бий болоод зогсохгүй нийгэмд эерэг өөрчлөлтүүдийг авчрах боломжтой юм. Ингэхдээ хөрөнгийг өвлөн авч буй хүнээс нь хамааруулан татвараас хөнгөлөх боломжийг олгох, дундаж давхаргын иргэдэд дарамт учруулалгүй нийгмийн баялгаас хамгийн их хэмжээний баялаг хүртэж буй давхаргад татварын ачаалал очиж байхаар татвараас чөлөөлөх дүнг тодорхойлж өгөх нь хамгийн зөв шийдэл гэж үзэж байна. Цаашид бусад орнуудын туршлагыг судлах замаар өв залгамжлалын татварыг хэрхэн ногдуулах асуудлыг авч үзэх боломжтой.

Ашигласан материал

1. Fessler, Pirmin, Martin Schürz (2018). Private Wealth across European Countries: The Role of Income, Inheritance and the Welfare State. *Journal of Human Development and Capabilities*, 19(4), 521–549.
2. Gilliam J.F. (1952). The minimum subject to the Vicesima Hereditatum. *The American journal of philology*, 1952(4), 397-405.
3. Semyonov, Moshe and Noah Lewin-Epstein (2013). Ways to richness: Determination of household wealth in 16 countries. *European Sociological Review*, 29(6), 1134–1148.
4. Брючко Татьяна Александровна. (2011). Раздел наследства в гаржданском праве: вопросы теории и практики <http://dissercat.com/> Судалгааны ажил
5. Демин А.В. Полемиические заметки о предыстории налогов и налогообложения. *Финансовое право* №5. 2010, 19-27
6. Львов Д. Налог с наследства Ч. 1. Казань: Типо-литография Императорского университета. 1983. 498 с.
7. Ариунзаяа Н. (2003). Олон улсын хувийн эрх зүй дэх өв залгамжлалын асуудал. Судалгааны ажил. <https://catalog.num.edu.mn/>
8. Батболд А. (1998). Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт. Судалгааны ажил. <https://catalog.num.edu.mn/>
9. Ёсихиро А. Японы өнөөгийн тусгал, *Nippon.com*. 2014-12-22
10. Нарангэрэл Н. (2013). Монгол, БНХАУ-ын өв залгамжлалын хуулийн харьцуулсан судалгаа. Судалгааны ажил. <https://catalog.num.edu.mn/>
11. Оюунаа Ц. (2017). Өв залгамжлалын эрхзүй, олон улсын хувийн эрхзүйн хүрээн дэх судалгаа
12. Римское частное право/ под редакцией И.Б. Новицкого и И.С. Перетерского. М.: Юристь. 1999. 512с.
13. Улаанбаатар Б. (2018). Гэрээслэлээр өв залгамжлалын эрх зүйн шинэчлэлтийн тулгуур асуудал. Докторын диссертаци. <https://catalog.num.edu.mn/>
14. Юевич Н. М. Исторические аспекты налогов на оборот недвижимого имущества журнал *Финансы и кредит* 2013. №29. 78-83 с.
15. Янжул И.И. Основные начала финансовой науки: учение о государственных доходах. М.: Статун. 2002. 555 с.
16. <https://www.assa.mn/a/16642>
17. <https://www.bdsec.mn/>
18. <http://lehmanlaw.mn/blog/>
19. <https://www.legalinfo.mn/>
20. <https://www.oecd.org/>